

**ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ХАН ТУУЛ ТӨВИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭЖИЛТНИЙ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ТАЙЛАН**

2026.05.30

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Үйл ажиллагааны хэрэгжилт
1	Тусламж үйлчилгээний чанарын магадлан итгэмжлэлийн хугацааг сунгуулах, үйл ажиллагааны бэлтгэл хангахад оролцох	Магадлан итгэмжлэлийн тайланд өөрийн хариуцан авсан бүлгийг хугацаанд нь өгсөн. Нийт магадлангийн материалыг нэгтгэх, засах үйл ажиллагаанд оролцсон.
2	Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлтэй хүүхэд болон асран хамгаалагч нарт эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах	Сувилахуйн албатай хамтран оны эхэнд асран хамгаалагч нарт орох сургалтын төлөвлөгөөг төвийн даргаар батлуулан шаардлагатай танилцуулах материалыг бүрдүүлж хавтасласан. Эхний хагас жилийн байдлаар 10 төрлийн сэдвээр 17 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 189 хүнд зохион байгуулсан.
3	Хөгжлийн хоцрогдол бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	ХУД-ийн 2-р хорооны 72-р цэцэрлэгт 3 сарын 4, 6нд Хүүхдийн хөгжлийн эрт илрүүлэг зохион байгуулсан. Тухайн үйл ажиллагаанд цэцэрлэгийн нийт 313 хүүхэд хамрагдсан.
4	Төвийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нийтийн эрүүл мэндийн хөтөлбөр боловсруулж, арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах	Төвийн үйл ажиллагааны онцлогт тохируулан “Урлахуйн хөтөлбөр” боловсруулан батлуулж хүүхдийн сэтгэн бодох чадвар, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх, хүүхэд хүүхдээсээ суралцах чадварыг дэмжих зорилготойгоор усан будаг, гуаш, харандаа, пламастер, хайчилбар, наамал, нугалбар зэргээр бүтээл хийлгэж байна. Энэхүү хөтөлбөрт 2026 оны эхний хагас байдлаар хэвтэн эмчлүүлэгч 127 хүүхэд хамрагдсан.
5	Байгууллагын пейж хуудас, веб сайтад сэргээн засах эмчилгээ, асаргааны талаарх мэдээллийг тогтмол хийж хөгжүүлэлтийг хангах	Байгууллагын пэйж хуудсанд төвийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, сургалт, ЭМБО мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж байна. Эхний хагас жилийн байдлаар 62 төрлийн мэдээ мэдээлэл байршуулан 86,336 хандалт авсан. Веб хуудасны засварын ажлыг төвийн гэрээт IT хийж байна.
6	Эрүүл мэндийн ажилтныг ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж гадаад, дотоод сургалтад хамруулах	Төвийн 2026 оны сургалтын төлөвлөгөөг батлуулан 05 сарын 27-ны байдлаар төлөвлөгөөний дагуу 15 төрлийн сургалтыг давхардсан тоогоор 264 ажилтнуудад зохион байгуулсан. Үүнээс гадаад сургалт 7, дотоод сургалт 8 удаа зохион байгуулсан.

7	Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах холбогдох сайтад мэдээллийг хугацаанд нь байршуулах	Shilen.gov.mn сайтад мэдээллийг байршуулан ирсэн бичгийн дагуу мэдээллийг илгээх сүүлийн хугацаа болох 3 сарын 31нд илгээсэн.
8	Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх болон эрүүл мэндийн боловсрол олгох тараах материал бэлтгэнэ.	Цаасан хэлбэрээр 2 төрлийн тараах материалыг бэлтгэн гаргасан. Үүнд: • Эцэг эхчүүдийн хүүхдэдээ үзүүлэх дэмжлэг • Хүүхдийн хоол тэжээл ба өсөлт хөгжил
9	Байгууллагын дотоод тохижилтыг сайжруулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	SUVD ART байгууллагатай хамтран төвийн үүдний хэсгийн тохижилтийг хийж гүйцэтгэсэн. Kids all хүүхдийн тавилгын дэлгүүртэй хамтран хүүхдийн номын буланг тохижуулж үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн. Barlo world ХХК-руу илгээсэн төсөл дэмжигдэж “Хүүхдийн тайвшруулах гэрэл эмчилгээний өрөө”-г тохижуулах ажлын хүрээнд Хөрөнгө оруулалт хийх гэрээ хийгдсэн. 06 сарын 07-ноос эхлэн засварын ажил эхлэнэ.
10	Байгууллага сурталчилах үйл ажиллагаа болон Дэлхийн тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулах	04 сарын 01нд “Аутизм ба боловсрол” олон улсын конференцэд Төвийн дарга Х. Уянга, Яаралтай тусламжийн их эмч Б. Санчирмаа, НЭМА Б. Ганцэцэг нар оролцсон. Монголын Аутизмын холбооноос 2 дах жилдээ зохион байгуулж буй “autism awareness day 2026” мэдээллийн яармагт 04 сарын 02-ны өдөр хүүхдийн их эмч Г. Сэржхорлоо, НЭМА Б. Ганцэцэг нар төвийн үйл ажиллагааг олон нийтэд танилцуулж мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгсөн Монголын аутизмын холбоотой хамтран 04 сарын 07нд төвийн ажилтан болон асран хамгаалагч 57 хүнд аутизмтай хүүхдийн сөрөг зан үйлийг зохицуулах тухай сургалт зохион байгуулсан. Сургалтыг Аутизмын холбооны сургагч багш Ууганбаяр, гишүүн н. Алтаншагай удирдан явуулсан. Аутизмын холбоотой хамтран зохион байгуулж буй арга хэмжээнд зориулан хөлтэй стөндний загвар гаргаж батлуулан хэвлүүлж үйл ажиллагаануудад хэрэглэсэн. 4 сарын 21-22нд Сүхбаатарын талбай дээр “Эрүүл мэндийн нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож нийт 151 хүнд байгууллагын үйл ажиллагааг сурталчилах үзлэг, оношлогоо, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.

Тайлан бичсэн: Б. Ганцэцэг